

## ХҮН АМ БА ЯДУУРАЛ

### *“Дэлхийн хүн амын илтгэл, 2002”-ыг түгээхэд зориулан МУ-ын НХХЯ-ны захиалгаар бэлтгэв*

Н.Өлзийбат,  
Сэтгүүлч, “Өдрийн сонин” хэвлэлийн газар

*Аливаа улс орны тогтвортой хөгжлийн нэг үндсэн баталгаа бол хүн амын амьжиргааны түвшингийн эрс ялгааг багасгах, ядуурлыг бууруулах явдал гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Хүн амын асуудлаархи дэлхийн Дээд хэмжээний чуулга уулзалт, бага хурлын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор Дэлхийн хүн амын өдрийг энэ онд “Ядуурал, хүн ам ба хөгжил” уриан дор зарлаж, ядуурлыг бууруулах асуудалд хүн төрөлхтний анхаарлыг хандуулж байгаа билээ.*

*Энэхүү нийтлэл нь “Хүн ам ба Ядуурал” сэдэвтэйгээр хэвлэгдэн гарсан Дэлхийн Хүн Амын Илтгэлийг түгээхэд зориулан бэлтгэгдсэн товчлол-нийтлэл юм. Эндээс та бүхэн дэлхий дахинаа ядуурлын асуудал хэрхэн тавигдаж, нийгэм, хүн амын дунд ямар үр дагавар үзүүлж байгаа талаарх илтгэлд дурьдагдсан судалгааны үр дүнгүүдтэй танилцахын зэрэгцээ ядуурлын төрөл, хэв шинжүүд, ядууралд нөлөөлж буй зарим хүчин зүйл, ядуурлын шалтгааны сүлжээ, ядуурлыг хэмжих аргын талаар тодорхой мэдээллийг авах болно.*

... Ядуурал дэлхийн хэмжээний тулгамдсан асуудал хэвээр байна. Үүнийг НҮБ-ын Хүн амын сангаас "Хүн ам ба Ядуурал" сэдвээр бичиж, хэвлүүлэн гаргасан "Дэлхийн хүн амын байдал 2002 онд" илтгэл нотолж байна. Уг илтгэл нь "Ядуурлын хэв шинж", "Макро эдийн засаг, ядуурал, хүн ам ба хөгжил", "Эмэгтэйчүүд ба жендэрийн тэгш бус байдал", "Эрүүл мэнд ба ядуурал", "Хүн ам, ядуурал, Дэлхийн хөгжлийн зорилтууд" гэсэн бүлгүүдтэй бөгөөд ядуурлын асуудлаархи хэлэлцүүлэгт хувь нэмэр болж, цаашид авах арга хэмжээнд анхаарал хандуулахад чиглэснийг НҮБ-ын Хүн амын сангаас онцлон тэмдэглэжээ.

1960-аад оноос хойш дэлхий дахинаа өсөн нэмэгдэж буй хүн амын гурван тэрбум гаруй нь өдөрт хоёр ам. долларт хүрэхээргүй бага орлогоор амь зууж байгаа ажээ. Хэдийгээр ядуурал нэмэгдэхэд хүн амын үзүүлж буй нөлөөлөл шууд биш ч ядуурал, түүнээс гарах арга замыг хэлэлцэхэд хүн амын хүчин зүйлийг орхигдуулах ёсгүйг илтгэлд дурдсан байна.

... Нэн ядуу улс орнуудад хүн амын өсөлт болон төрөлт илүү өндөр байна. Буурай хөгжилтэй орнуудын хүн ам 1995 онд 600 сая байсан бол 2015 онд гурав дахин өсөх тооцоо гарчээ.

... Хүн амын насны бүтэц нь хөгжилд нөлөөлдөг. Хүн ам залуу байх тусам тэжээлгэгч хүн амын тоо өсч байдаг.

... Хотын хүн амын өсөлт ядуу хүн амын дунд хурдацтай байна. Хотод шилжин ирэгсдийн ихэнх нь байгалийн гамшиг, эдийн засгийн хүнд нөхцөл, амьдрал ядуугаас улбаатай байдаг.

Ядууралтай холбоотой эдгээр болон бусад баримтыг энэхүү илтгэлд тодорхой дурьдсаны зэрэгцээ ядуурлын төрөл, цаашдын хэв шинжүүд, ядууралд нөлөөлж буй зарим хүчин зүйл, ядуурлын шалтгааны сүлжээ, ядуурлыг хэмжих аргын талаар өргөн мэдээллийг багтаажээ. Эдгээрээс хураангуйлан та бүхэнд хүргэе.

## **Ядуурлын төрөл**

Ядуурлын нэг үндсэн төрөл нь орлогын ядуурал юм. Орлого нь ядуурлыг хэмждэг үндсэн хэмжүүр мөн боловч ядуурал түүнээс гадна олон хүчин зүйлээс хамаардаг. Ядуучууд хөрөнгө, эх үүсвэр, боломж, үйлчилгээ болон мөнгөөр байнга гачигдаж байдаг. Тэдний хязгаарлагдмал нөөц бололцоо нь үр ашиг муутай ашиглагддаг. Эрчим хүч, хүнсний зүйл гэх зэрэг бүх зардал нэг хүнд ногдохоор тооцоологддог учир ядуурал нь өөрөө ядуу хүнд маш үнэтэй тусч байдаг. Ядуурлаас гарах явдал хувь хүний өөрийн чадварыг сайжруулах, бүх төрлийн эх үүсвэр хүртэх боломжийг нэмэгдүүлэх, үүнийг дэмжих орчин механизмуудыг бүрдүүлэхээс шууд хамаардаг ажээ.

*Орлогын ядуурал дэлхийн улс орнуудад: Сүүлийн гучин жилд дэлхийн эдийн засаг маш хурдацтай өссөн ч энэхүү өсөлт бүс нутаг болгонд, улс орон бүрт, тэр ч байтугай тухайн улс орны дотор ч ялгаатай байж иржээ. Гэвч орлогын ядуурал байсаар байгаа бөгөөд олон оронд улам гүнзгийрч байна. Зардлын аргачлалд тулгуурлан тооцож үзэхэд, хөгжиж буй орнуудад өдөрт нэг ам. долларын орлогоор амьдарч байгаа хүмүүсийн эзлэх хувь 1987 онд 28.3 байснаа 1998 онд 23.4 хувь болж буурчээ. Энэ хугацаанд хүн амын үнэмлэхүй тооны өсөлт харьцангуй тогтвортой буюу 1.2 тэрбум байсан. Дээрх үзүүлэлтийн эерэг өөрчлөлтөд Хятадын эдийн засгийн өсөлт ихээхэн нөлөө үзүүлсэн гэдгийг олон орнууд хүлээн зөвшөөрч байгаа ажээ.*

*Гэсэн хэдий ч ядуурлын бууралт улс орнуудад харилцан адилгүй байна. Жишээ нь, Зүүн Азийн орнуудад, ялангуяа Хятад улсад ядуурал хурдацтай буурч, харин Зүүн Европын болон Төв Азийн орнуудад ядуурал өсч, Өмнөд Ази болон Африкийн орнуудад ядуучууд олширчээ. Ойрхи Дорнод хийгээд Латин Америкийн орнуудын хувьд ядуурал бага хэмжээгээр буурсан байна. Сүүлийн үед орлогын ядуурлыг эдийн засгийн эмзэг байдалтай холбон өргөн хүрээнд авч үзэх хандлагатай болжээ. Энэ нь хувь хүмүүс, гэр бүл эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан ажилгүйчүүдийн эгнээнд орж, эрүүл мэнд нь доройтох зэргээр ядуурал руу гулсан орж байгаагаар тайлбарлагдаж байна.*

## **Ядуурлын цаашдын хэв шинжүүд**

Ядуу хүн хүч чадалгүй, аюултай эрсдэл, эмзэг байдлыг байнга мэдэрч байдаг. Тэд энэ байдлаа сайжруулах арга хэмжээ авах бус, өөрсдийнх нь амьдралын талаар гаргах бусдын шийдвэрээс хараат амьдарч байдаг. Эрүүл мэндийн байдал нь дорой тул бага цалинтай, тогтвортой бус хөдөлмөр эрхлэхэд хүргэдэг. Нэн ядуу байдалд амьдарч байгаа хүмүүст ядуурлаас гарах

арга зам хомс байдаг. Тэдний үндсэн хэрэгцээгээ хангах гэсэн оролдлого нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн олон бэрхшээлтэй тулгарч байдаг. Ялангуяа эмэгтэйчүүд хүчирхийлэлд байнга өртөж байдаг. Ядуу хүмүүсийн хувьд шинэ санаачилга гаргана гэдэг нь гол төлөв эрсдэлтэй байдаг бөгөөд энэ эрсдэл нь эргэж сэхэхээргүй болгож ч мэдэх ажээ.

### **Ядууралд нөлөөлж буй хүчин зүйлс**

Эрүүл мэндийн дорой байдал: Хөгжиж буй нэлээд оронд хүн амын хурдацтай өсөлт хүн ам хэт шигүү оршин суух, ундны усны бохирдол, эрүүл ахуйн нөхцөл муу байх зэрэгт нөлөөлж байдаг. Ядуу хүн олноор оршин сууж буй газарт эрүүл мэндийн суурь үйлчилгээ, эм тариа болон дархлаажуулалтын ажил хоцрогдож байна. Эрүүл мэндийн дорой байдал нь орлогын ядуурлын шалтгаан төдийгүй үр дагавар болж байна. Эрүүл мэндээр дорой байх нь хувь хүний чадамж, бүтээмжийг бууруулж, улмаар орлогод нөлөөлнө. Бүтээмж муу байх нь цалин хөлстэй холбоотой. Учир нь тэд боловсрол, мэдлэг муутайгаас ихэвчлэн биеийн хүчний ажил хийдэг тул тэднийг орлуулахад амархан байдаг. Аливаа улсад бий болсон өвчлөлийн өндөр түвшин эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг. Хүн амын дийлэнх нь малари өвчний эрсдэлд байдаг орнуудын хүн амын дундаж орлого малари өвчингүй орнуудтай харьцуулахад 20 хувь доогуур байдаг байна. Нөгөө талаар дундаж наслалт эрүүл мэндийн нэг гол үзүүлэлт болж байдаг ба эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг. 1965, 1990 оны хооронд 53 орны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр, насанд хүрэгчдийн дунд амьдрах магадлал дээгүүр байсан нь эдийн засгийн өсөлтийн найман хувийг бий болгосон гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ нь ажиллах хүч эрүүл чийрэг байж, тогтвортой ажиллахад тэдний хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж байдаг бөгөөд хувь хүн болон ажил олгогчид ажиллах хүчиндээ хөрөнгө оруулалт хийх сонирхол нэмэгддэг. Мөн дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр ажилчид тэтгэвэрт гарахдаа зориулж эртнээс хадгаламж хийж эхэлдэг, хадгаламж нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг.

Бичиг үсэггүй байдал, хангалтгүй боловсрол: Бичиг үсэг үл мэдэх явдал хувь хүний өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг багасгадаг. Сургуульд сурахгүй байгаа тохиолдолд шинэ шинэ боломжоос хөндийрч байгаа хэрэг. Боловсрол багатай хүмүүс ойр дотнынхноосоо гадуур олон нийтийн дунд өөрийнхөө байдлыг амаар болон бичгээр илэрхийлэхдээ муу, ерөнхийдөө нийгмийн өргөн хүрээнээс тусгаарлагдаж байна. Ядуурлын бусад хүчин зүйлтэй адил боловсрол, эрүүл мэнд хоёр нь ядууралтай салшгүй холбоотой. Боловсрол багатай хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл авах боломж хомс байдаг. Эрүүл мэнд дорой, амьдрах магадлал доогуур байгаа хүмүүс хүүхдээ сургуульд явуулахад хөрөнгө оруулалт хийх сонирхол бага байдаг ажээ.

Нийгмийн хавчлага болон эрх мэдэлгүй байдал: Ядуурал нийгмийн тогтолцоонд өөр нэг хэлбэрээр оршин тогтнож байдаг. Нийгмийн тогтолцоо зарим бүлгийн нийгмийн тэгш эрхт гишүүдийн хувьд оролцох эрх чөлөө болон эрх ашгийг нь үгүйсгэж байдаг. Энэ байдал цөөн биш улс оронд олон тооны хүнийг нийгмийн хөгжилд чөлөөтэй оролцох боломжийг хааж байна.

Жендэрийн ялгаа ядууралд: Ихэнх нийгэмд материаллаг зүйлийн ядуурал жендэрээр ялгаварлан гадуурхах байдалтай холбоотой бөгөөд тиймээс ядуу

эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсролын түвшин болон нийгмийн оролцоо ядуу эрэгтэйчүүдтэй харьцуулахад доогуур байдаг.

### **Ядуурлын шалтгааны сүлжээ**

Ядуурлыг хэмжих, хөтөлбөр төслүүдийг төлөвлөх, үнэлэхэдээ ядуурлын янз бүрийн шалтгаан, тэдгээрийн үр дагавар, хоорондын холбоо, хамаарлыг бүрэн хэмжээнд тусгаж чаддаггүй. Хөгжлийн талаархи шинэ баримтлал болох хэн хөгжлийн үйл явцаас хоцорч байна вэ гэсэн баримтлалд засаглалын чанар, үр нөлөө, хууль дүрэм, хээл хахууль, гэмт хэрэг, соёл уламжлалын болон түүхийн хүчин зүйлсийг хамруулж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2000 оны Хүний хөгжлийн илтгэлд дэлхийн улс оронд хүний эрхийн асуудал ямар байгаад анхаарлаа хандуулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс тооцдог хүний хөгжлийн индекс улс орнуудын хүн амын боловсрол, эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгдөг. Дэлхийн банкнаас ядуучуудын дуу хоолойг сонсон, тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд улс орнуудын анхаарлыг хандуулж байна.

### **Хүн ам зүйн шилжилтийн нөлөө**

Эрүүл мэндийн салбарт гарсан ололт, хөгжиж буй орнууд анагаах ухааны технологийг өргөн хэмжээгээр гаднаас импортлох болсны үр дүнд 1950-иад онд нас баралтын түвшин буурч, хүн ам хурдацтай өссөн. Гэвч ядуу буурай улс орнуудын хувьд төрөлт буурах үйл явц удаан байлаа. Энэ нь эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Хүн амын хурдацтай өсөлт, өсөн нэмэгдэж буй хүн амыг тэжээх нөөц, эх үүсвэрийн хоорондын тэнцвэртэй бус байдал нийгмийн байгууллын хязгаарлагдмал бололцоог шавхаж, ядууст үйлчилдэг байгууллагуудад дарамт бий болгож байна. Өрхийн түвшинд мөн адил төрөлт өндөр байхад тэжээлгэгчдээс үзүүлэх дарамтыг нэмэгдүүлнэ.

Улс орнууд хүн ам зүйн шилжилтийн үйл явцад ороход төрөлт буурч, түр хугацаагаар боломжийн цонх нээгдэх бөгөөд тодорхой хэмжээний хөрөнгө нөөцтэй гэр бүлд хүүхдүүдээ сургах, боломжийн ажил эрхлэх, хөрөнгө хуримтлуулах боломж бий болдог. Харин ядуучуудын төрөлт хамгийн сүүлд буурдаг тул дээрх боломжийг ашиглаж тэр бүр чаддаггүй байна. Өөрчлөгдөж буй нийгэмд олон хүүхэдтэй байхын зардал ба үр ашгийг тооцох мэдрэмж ядуучуудад бага байдаг. Төрөлт буурах нь удаан хугацааны дараа ядуурал буурахад нөлөө үзүүлнэ.

Сүүлийн тавин жилд Бразили улсад бий болсон хүн ам зүйн өөрчлөлт нэг хүнд ногдох нэмэгдэл орлогын 0.4-0.5 хувьтай тэнцэж байгаа юм. Энэ хугацаанд нэг хүнд ногдох орлогын өсөлт дунджаар гурав орчим хувь байжээ. Энэ тооцоогоор, хүн ам зүйн хүчин зүйлийн ядууралд үзүүлэх шууд нөлөө эдийн засгийн өсөлтийн 15 хувьтай тэнцэх ажээ.

### **Ядуурлыг хэмжих нь**

Ядууралд үнэлгээ өгөхөд гурван үндсэн арга ашигладаг. Эдгээр нь,

- Ядуурлын шугамыг тодорхойлох замаар энэ шугамаас доогуур хэрэглээтэй өрх, хүн амын талаархи янз бүрийн үзүүлэлт гаргах

- Хүмүүс өөрсдөө оролцож айл өрхүүдийг чинээлэг байдлаар жагсаах замаар оролцооны болон хурдавчилсан аргаар үнэлгээ хийх
- Тоо болон чанарын янз бүрийн үзүүлэлт ашиглаж ядуурлын индекс тооцох.

### **Хүн ам, Хөгжил ба Мянганы хөгжлийн зорилтууд**

Олон улсын хамтын нийгэмлэг 2015 он гэхэд туйлын ядуу амьдарч буй хүн амыг тэн хагас хувиар бууруулах амаргүй зорилт дэвшүүлсэн. Дэлхийн улс гүрнүүдийн тэргүүн нар Мянганы хөгжлийн зорилтуудад багтаж буй найман зорилтод хүрэхийн тулд хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх /эрүүл мэндийн хэмжүүр/, боловсрол, орон сууц, жөндөрийн тэгш байдал, худалдааны чөлөөт байдал, байгаль орчныг хамгаалах чиглэлээр нэлээд хэдэн тодорхой зорилт тунхагласан. Эдгээр шинэ зорилтоор ядуурал бол хүний оршин тогтнол, боломж, сонголт, орлогын талаархи асуудал юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Ядуурлыг гэтлэн туулна гэдэг нь зөвхөн хувь хүнээс хамаарах зүйл биш. Ядуурал бол гэр бүл, байгууллага, нийгэм, хамт олон, төр, хувийн салбар, соёл, шашны байгууллагуудын дэмжлэг, тэдний зүгээс бий болгож буй улс төр, эдийн засаг, нийгмийн орчин болон боломж дэмжлэгээс хамаарна.

*Тэгвэл ядуурлыг бууруулах зорилтыг яаж хэрэгжүүлэх вэ?*

Эдийн засгийн өсөлт нь хангалттай түвшинд биш байгаа улс орнууд хөгжлийн хүчин чармайлтаа ядуучуудад чиглүүлэх ёстой. Олон улсын хамтын нийгэмлэг ядуурлын асуудлыг харгалзан үзэж, зах зээлээс гадна өргөн хүрээнд асуудлыг харж, хөгжлийг дэмжсэн олон улсын хамтын ажиллагааны орчин бүрдүүлэхэд анхаарах ёстой гэж "Дэлхийн хүн амын байдал 2002 онд" илтгэлд өгүүлжээ.

### **Ном зүй:**

---

1. НҮБХАС, "Дэлхийн хүн амын байдал 2002 онд: Хүн ам ба Ядуурал", илтгэл